

6-8 НАСНЫ СУРАГЧДЫН СЭТГЭХҮЙН ҮЙЛДЛИЙН ХӨГЖЛИЙГ СУДЛАХ АСУУДАЛД

Я.Цэвээнлхаазал дэд профессор БС

Краткое содержание: В этой статье мы старались обработать методику диагностики выявления особенностей мыслительных процессов учащихся 6-8 летних возрастов на примерах выполнения практических упражнений и работ по монгольскому языку. А также определить некоторых возможностей применения диагностических методик по развитию мыслительных операций в процессе сочинения простых текстов

Түлхүүр үг, тулгуур ухагдахуун:

Тухайн суралцагчийн сэтгэхүйн хөгжил, төлөвшил нь тэднээс нийгэм, соёлтой хэрхэн харилцаж, үзэл хандлагаа яаж өөрчилдөг болсноос хамаардаг гэж Л.С.Выготскийн нийгэм, соёлын онолд үздэг.

Ж.Пиажегийн онол ёсоор, хүүхдийн сэтгэхүйн хөгжил, төлөвшил нь тухайн суралцагчийн орчинтой харилцан үйлчлэлцэх үйл явц, түүний тэнцвэржилтийн өөрчлөлтөөр хувьсаж шинэчлэгдэж байдаг.

Ж.Брунерийн онол нь суралцагч өөрийн эзэмшсэн арга, туршлагадаа тулгуурлан мэдлэгийг зохиомжлон бүтээх явцдаа сэтгэхүй нь хөгжиж, төлөвшиж байдаг гэж сургадаг.

Сурагч бие хүмүүний сэтгэхүй нь нэг талаас, биологийн хүчин зүйл, нөгөө талаас, нийгмийн олон талт нөлөөллийн дор бүрэлдэн тогтдог цогц үйл явц, сэтгэхүйн чанар, оюуны арга барилын нэгдмэл үр дүн юм.

Тухайн сурагчийн сэтгэхүйн хөгжлийн тодорхой үе шатыг оюуны хөгжлийн төлөв байдал гэнэ. Суралцагчийн сэтгэхүйн хөгжлийн төлөв байдал нь түүний оюуны арга барил, сэтгэхүйн чанарын төлөвшлөөр тодорхойлогдоно.

Америкийн сэтгэлзүйч Л.Теорстоун /1938/, Х.Гарднер /1986/ нар "Тухайн суралцагчийн оюун ухаан, сэтгэхүйн үйлдлийн чадамжийн багц нь оюун ухааны хөгжлийг илэрхийлдэг" гэсэн онолыг боловсруулсан байна.

Л.Теорстоуны /1938/ онол нь оюун ухааны чадамжийн багц нь тоолох, арифметик үйлдэл хийх, хамгийн тохиромжтой үгээр өөрийн санаагаа хялбархан ойлгуулах, үг яриаг хүртэх, аман ба бичгийн хэлийг ойлгох зэрэг хэл ярианы уян хатан чанар, орон зайг баримжаалах, юмсын хэлбэр дүрсийг орон зайд төсөөлөх, ой тогтоолт, эргэцүүлэн бодох хурд, юмс үзэгдэл, тэдгээрийн хоорондын холбоо хамаарал, адил төстэй болон ялгаатай талуудыг түргэн олох зэрэг сэтгэхүйн болон оюун ухааны 7 цогц чадамжийг агуулдаг гэж тайлбарладаг.

Х.Гарднерийн /1986 он/ оюун ухааны хөгжлийн цогцолбор онол ёсоор, оюун ухааны чадамжийн багц нь өөртөө хэл ярианы, хөгжмийн, математик логикийн, орон зайн, биеийн хөдөлгөөн тэнцвэрийн, хүмүүс хоорондын харилцааны, өөртөө тунгаан бодох буюу бясалгах чиглэл давамгайлах гэсэн 7 цогц чадамжийг агуулдаг гэж үздэг. Тэрээр сэтгэхүйн хөгжилд илүү ач холбогдол өгдөг байсан байна.

Сэтгэхүйн бүтээмж (СБ) нь даалгавруудад өгөгдсөн нийт онооноос алдаагүй гүйцэтгэсэн оноог хасч тооцсон үр дүнг нийт оноонд харьцуулж гарсан тоог нэгж секундэд хувааж гаргасан математик харьцаа болно.

Сэтгэхүйн ерөнхий бүтээмж (СЕБ) нь монгол хэлний эх зохиох, математикийн бодлого бодох, геометрийн дүрс ашиглан дүр бүтээх практик даалгавруудыг гүйцэтгэхэд илэрсэн оюуны ерөнхий бүтээмж юм.

Сэтгэхүйн дундаж бүтээмж (СДБ) нь нэг төрлийн практик даалгавруудыг гүйцэтгэх явцад илэрч байдаг оюуны бүтээмжүүдийн хувьсах (динамика) өөрчлөлтөөр тодорхойлогдоно.

Асуудлыг үндэслэх тухайд:

ОХУ-ын сэтгэлзүйч эрдэмтэд П.П.Блонский (1924), Л.С.Выготский (1930), Л.С.Рубинштейн (1940), П.Я.Гальперин, А.Я.Пономарев (1950, 1960), Н.А.Менчинская, В.В.Давыдов, Д.Б.Эльконин, Л.В.Занков, М.К.Мамардашвили, Л.Л.Гурова (1960, 1980) нар 6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдэл сургалтын явцад эрчимтэй хөгжиж байдгийг судлан тоосон байна.

Сэтгэл судлагч эрдэмтэд Дж.Метьюзда, Ж.Годфруа (Канад), К.Риччи (Итали), З.Фрейд (Австри), З.Деньеш (Астрали), Ж.Пиаже (Швейцарь), Н.Идэ (Япон), Д.Б.Уотсон, А.Маслоу,

Ж.Брунер, Х.Гарднер, Р.Келлог, Р.Л.Солсо, Е.Бигл, П.Саппс, Р.Давис (АНУ) нар хүүхдийн сэтгэхүй нь танин мэдэх болон мэдлэг эзэмших үйлийн явцад төлөвшин бүрэлдэж, оюуны цогц чадамж болон дэвшин хөгжиж, тэдний авьяас билгийн үндэс суурь болдгийг нээжээ.

Ж.Пиаже 0-2 хүртэлх насанд “сэрж мэдрэх үйлдлийн”, 2-7 хүртэлх насанд “сэтгэхүйн тодорхой үйлдлийн”, 12-15 насанд “сэтгэхүйн үйлдэл идэвхтэй хийх” үеүд гэж онолын хувьд тодорхойлсон байдаг.

Л.С.Выготский 6-8 насны сурагчдад биет үйлдлийн сэтгэхүйгээс дүрслэлт сэтгэхүй, түүнээс утгын сэтгэхүйд, түүнээс сэтгэхүйн дээд нарийн үйлдэлд дэс дараалан шилжин хөгждөг зүй тогтол, хуулийг нээсэн байна.

6-8 насны сурагчдын амьдралын туршлага нэмэгдэж, мэдлэгийн хүрээ өсөх тутам тэд ямар нэг зорилтыг дан ганц практик үйл ажиллагааны үйлдлээр бус, харин “бодож сэтгэх сэтгэлгээний хэлбэр”-ийг ашиглан асуудлыг шийдвэрлэж сурдаг байна. Ингэж тэдэнд сэтгэхүйн нарийн үйлдлүүд бүрэлдэн тогтож хөгжинө.

Эрдэмтэн зохиолч Л.Түдэв, Д.Санжжав, Б.Бор, А.Загдаа, Б.Дамдинсүрэн, Д.Дашхүү, Я.Сэндэрмаа, Ж.Батдэлгэр, О.Мягмар, П.Цэрэндондов, Б.Балдулмаа, Ц.Нямжав, Д.Цэдэн-Иш, Ч.Цэдэнбал, М.Мөнхжаргал, Д.Энхцэцэг, М.Хишиг-Ундрах, Г.Батцэнгэл, Ц.Баттуяа, Д.Одгэрэл, Г.Эрдэнэ-Очир нарын зэрэг монголын сурган хүмүүжүүлэгч 6-8 насны эрүүл ба хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сэтгэхүй, хэл ярианы хөгжлийн онцлогийг танхимын болон танхимын бус сургалтын явцад судалсан байна.

Монгол хүүхдийн сэтгэхүйн үйлдэл ахуйтайгаа нягт холбогдон хөгждөг байна. Энэ талаар ардын уран зохиолч, доктор, профессор Л.Түдэв “Хорвоотой танилцсан түүх” зохиолдоо: “... Хорвоо бид хоёр мэндлэлцсэн тэр цагаас эхлээд нэг талд би, нөгөө талд хорвоо эсрэг ширтэлцэн орших болов оо. Намайг өмссөн цамц ч үгүй гар хоосон төрөхөд хорвоо яндашгүй баян байлаа. Би энгийн хялбар амьтан төрж байхад хорвоо эдэрээтэй нарийн ертөнц байлаа. Хорвоо нууц. Хорвоо сүртэй. Би нялх. Би гэнэхэн. Гэвч би хорвоог таних ёстой.

...Тэгэвч аянаас зүрхшиж, алжаалаас айлгүй одсон эцэг өвгөдийн зам намайг хөтөлжээ. Надад таван сайн зэвсэг байлаа. Ихийг үзэж, ихийг сонс гэж нүд, чихийг хосоор, бага чалч гэж амыг ганцаар заяажээ. Зэвсгээ тийн агсаад, би танин мэдэхийн аянд гарсан билээ л”¹ -гэж хүүхдийн

сэтгэхүйн үйлдлийн танин мэдэх ач холбогдлыг оновчтой тодорхойлсон байна.

Тэрээр “... Хүүхэд төрснөөсөө хойш 3 насаа хүртэлх үед өөрийнхөө оюун ухааны хөгжлийн тэн хагасыг олж авдаг. 3-11 насандаа үлдсэн тал хувийг гүйцээгээд, илүү хөгжих нөөцийн эрэлд гардаг” гэж үзжээ.

6-8 НАСНЫ СУРАГЧДЫН СЭТГЭХҮЙН ҮЙЛДЛИЙГ МОНГОЛ ХЭЛНИЙ ЭХ ЗОХИОХ ЯВЦАД СУДЛАХ БОЛОМЖ

Зураг ба эгшигт үе ашиглан үг бүтээх даалгавар-1


Энэхүү даалгавар нь 6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэх чадварыг зураг ба эгшигт үе ашиглан үг бүтээх, бүтээсэн үгийнхээ санаа, утга, өгүүлэмжийг олж үндэслэх явцад илрүүлэх зорилготой байв.

Тухайлбал,

Алимаа гэсэн хүний нэр бүтээнэ. Бичиг үсэг мэдэхгүй хүүхэд шууд нэгтгэн хэлэх замаар бүтээнэ. Бичиг мэддэг сурагч ам ба бичгээр нэгэн зэрэг бүтээнэ. Үгийн санаа, утгыг өөрийн үгээр дэлгэрүүлэн тайлбарлана. Жишээ нь: Жимсний нэр хүний нэр болж хувирлаа гэх мэт.

Цэцгээ гэсэн хүний нэр бүтээнэ. Байгальд ургадаг сайхан цэцэг “Цэцгээ” гэдэг хүний нэр болж хувирлаа гэх мэтээр тайлбарлана.

Үзэмээ гэсэн хүний нэр бүтээнэ. Иддэг жимсний нэр, эмэгтэй хүний нэр болж хувирлаа. Хүнсний зүйлийн нэр үг, жинхэнэ нэрээр солигдлоо гэх мэтээр үндэслэн ярина.




Гармаа гэсэн хүний нэр бүтээнэ. Эрхтний нэрээс хүний нэр үүслээ. Тэр нь эрэгтэй хүний

1 Л.Түдэв. Хорвоотой танилцсан түүх. УБ., 2007 он., 3 тал


нэрийг төлөөлж байна гэх мэтээр дэлгэрүүлж, эх зохиож ярина.

Сарнай гэсэн хүний нэр бүтээнэ. Тэнгэрт байдаг од эрхсийн нэр эмэгтэй хүний нэр боллоо. Сарнай бол бас цэцгийн нэр гэх мэтчилэн дэлгэрүүлж ярьж бичнэ.



Судлуулагч-сурагчид иддэг жимсний нэр, Али-маа гэдэг хүний нэрээр, ургамлын нэр (цэцэг) Цэцгээ гэсэн хүний нэрээр, жимсний нэр Үзэмээ гэсэн хүний нэрээр, хүний эрхтний нэр (гар) Гармаа гэсэн хүний нэрээр, од гарагсын нэр (сар) Сарнай гэсэн хүний нэрээр тус тус солигдож, өөр утга санаа илэрхийлж байгааг ойлгож, өөрийн үгээр үндэслэн тайлбарлаж, өгүүлбэр зохиож сурснаар тэдний сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэх чадвар нь нэмэгдэж, эргэцүүлэн бодож ухаарах үйлд суралцаж хөгжинө. Жишээ нь "хүнсний зүйл, хүний нэр болж хувирлаа. Үүссэн нэр нь эмэгтэй хүний нэр байна" гэх мэтээр өгүүлбэр зохиох замаар сэтгэхүйн үйлдэл хийж, ерөнхийлөн нэгтгэн, дүгнэж сурч байлаа. Тухайн сурагчид энэхүү даалгаврыг гүйцэтгэх явцад сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэхэд суралцаж тэдний оюуны арга барил төлөвшин тогтож байв.

Зураг ашиглан, үг бүтээх даалгавар-2



Энэхүү даалгавар нь дүрсийг (нар, цэцэг) дүр болгон хувиргаж, тодорхой агуулгаар нэгтгэн, хоёр үгнээс бүтсэн нийлмэл нэр бүтээж, хүнд хамааруулж байгаа нь тухайн сурагчийн сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэх чадварыг хөгжүүлэн, дүрсийн утгыг үгийн утгат шилжүүлэн, өөрийн санааг илэрхийлж байгаа нь сэтгэхүйгээс оюуны арга барил хэрхэн үүсч байдгийг илрүүлэх боломж олгож байсан юм. Судалгаанд оролцсон 6-8 насны

сурагчид мишээж буй нар, дэлбээлж буй цэцгийн дүрсийг харж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх сэтгэхүйн үйлдэл хэрэглэж, ургуулан бодож, оюун дүгнэлт хийж, "Наранцэцэг" гэдэг хүний нийлмэл нэрийг бүтээж байлаа.

Өгөгдсөн үгээр өгүүлбэр бүтээх даалгавар-3

Энэ'	ний3	-сөн4	Мон6-	-гоб-
ми3-	төр4-	ну5-		сай7-
бол2	орон8	-таг5	-хан7	-лын6

Даалгавар-3 нь цифрийн дарааллыг ажиглаж, түүнийг ашиглан богино хугацаанд өгүүлбэр хурдан бүтээхэд оршиж байв.

Тухайлбал, "Энэ бол миний төрсөн нутаг, монголын сайхан орон" гэсэн өгүүлбэр бүтээж, энэ бол "Их зохиолч Д.Нацагдоржийн "Миний нутаг" шүлгийн хэсгээс байна" гэсэн дүгнэлтийг хийж, шүлгийн утга санааг олж, өөрийн үгээр тайлбарлах явдал байв.

Өгөгдсөн үсгүүдээр үг бүтээх даалгавар-4

Өгөгдсөн үсгүүд: Э, Г, З, Ү; О, М, Н; Э, Т, Р, Э, Д, В;

Зохиох ёстой үгүүд: үзэг, ном, дэвтэр

Энэхүү даалгаврын агуулга нь тодорхой үсгүүдийг ашиглан, утга бүхий үг бүтээхэд чиглэгдэж байв. Тухайлбал, "үзэг", "ном", "дэвтэр" гэсэн гурван өөр өөр утгыг өгүүлбэр зохиох явцдаа үндэслэн ярих даалгавар байлаа. Жишээ нь: "Үзгээр бичнэ. Номыг уншина. Дэвтэр дээр үзгээр маш цэвэрхэн бичнэ. Номын утгыг олох явцад ухаан тэлнэ. Үзэг бол эрдэм сурах чухал хэрэгсэл, хэрэглэгдэхүүн юм. Үзэг, ном, дэвтэр гурвыг ийнхүү хичээлийн хэрэгсэл гэж нэрлэнэ" гэх мэтээр тухайн судлуулагч-сурагчид эх зохиож, сэтгэхүйн үйлдэл хийж, хэрэглэх чадвараа нэмэгдүүлэх ёстой юм.

"Утга санааг олж батлах" даалгавар-5

а) Салангид үгсийг тогтоож, утгыг үндэслэх

Тогтоох үгс: аргал, хөдөлмөр, ирээдүй, хоньчин, өгүүлбэр, жигүүртэн, уламжлал, баялаг, эрмэлзэл, сурлага гэсэн хийсвэр утга бүхий 10 үг. Энэхүү даалгаврыг гүйцэтгэх явцад 6-8 насны сурагчдын ойн үйлдлүүд идэвхтэй оролцоно.

Харин утгыг сэтгэхүйн үйлдлийн үр дүнд олж, үндэслэлийг хэл яриагаар хийж сурдаг. 6-8 насны сурагчид үгийн утгыг өгүүлбэр зохиох замаар тайлбарлах ёстой. Жишээ нь: "Аргал бол түлш. Хөдөлмөр бол хүний үйл ажиллагааны нэг төрөл. Ирээдүй бол хүний амьдралын хэтийн төлөвийг тодорхойлно. Хоньчин бол малчин

хүний нэг төрлийн үйл ажиллагаа. Өгүүлбэр бол утга санааг төгс илэрхийлэх хэлний нэгэн төрөл юм. Жигүүртэн бол шувуудыг илэрхийлсэн нэр юм. Уламжлал нь шинэчлэлийн угтал, туулсан амьдралын замнал, туршлага юм. Баялаг нь оюуны ба материалын гэж байж болно. Эрмэлзэл нь хүний сэтгэл санаа, зорилгын нэг чухал илэрхийлэл. Сурлага нь сурах үйлийн үр дүн, ач холбогдлыг илэрхийлнэ" гэх мэтээр судлуулагч-сурагчид үгийн утгыг олж, өгүүлбэр зохиох замаар сэтгэхүйн үйлдэл, оюуны арга барил, сэтгэхүйн чанаруудаа хөгжүүлэх боломжтой юм. Өгүүлбэр зохиох явцад тэдний сэтгэхүйн уян хатан, хурдан, гүн чанарууд хурдан төлөвшиж байлаа.

б) Утгын холбоо бүхий арван хос үгийг агуулгаар нь зөв холбох даалгавар

морь-эмээл,
сонин-дэлхий,
байгаль-хөлөг,
шувуу-униар,
матар-харандаа,
утаа-яндан,
загас-үүр,
үзэг-хэвлэл,
зам-түлш,
аргал-гарц

Туршилт ажлын явцад 6-8 насны сурагчид үгийн утгыг олж, ойролцоо утгаар нь хоршоо үг бүтээж, өөрсдийн сэтгэхүйн

үйлдлийг хэрэглэх ёстой байв. Үүнд:

морь-эмээл,
сонин-хэвлэл,
байгаль-дэлхий,
шувуу-үүр,
матар-загас,
утаа-униар,
үзэг-харандаа,
зам-гарц,
аргал-түлш,
хөлөг-яндан гэж зөв холбож сурсан юм.

Энэхүү даалгаврыг гүйцэтгэх явцад 6-8 насны сурагчдын задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, жиших, хийсвэрлэх, ерөнхийлөх, тодруулах зэрэг сэтгэхүйн үйлдлүүд нэг дор зэрэг "багцран хөгжих" боломжтой нь ажиглагдаж байлаа.

Бид туршилт судалгааны ажлаа агуулгын хувьд улам хүндрүүлэн, шүлэг сонгон авч, далд утгыг нь олж, өөрийн үгээр үндэслэх, батлан ярьж, бичих даалгаварт шилжсэн юм.

в) Шүлэг тогтоолгож, далд утгыг үндэслэх даалгавар

"Зуун даага" наргиа шог
Зуун даага уралдана гэсэн
Сүр ихтэй зар
Зуны наадмын үеэр
Нэгэн нэгдэлд тарсан юм.

Эр даага бүртгэж Эмнэг бүгдийг сургавал
Дөнгөж дангаж сумаараа Дөчхөн даага болсон гэнэ.

Нээрээ энэ чинь юу вэ? гэж Нэгдлийн дарга гайхахад Ноднин жилийн төл гэж

Нойрноос сэрсэн шиг... орлогч нь харамсаж гэнэ.

Даалгавар-5-ын "в" -нь шүлгийг тогтоож, уран тод уншихын зэрэгцээ судлуулагч-сурагчид далд утгыг олж, өөрийн үгээр үндэслэх учиртай. Туршилт ажлын явцад дор дурдсан агуулгыг сурагчдаар олуулах ажил хийсэн юм. Үүнд:

"Зуун даага" гэсэн хоёр үгнээс бүтсэн нэрийн цаана хариуцлага султай ажлаа мэддэггүй дарга нарын үнэн байдлыг мэдэж, баримт жишээгээр нотлох оролдлого, эрэл хайлт хийх боломжтойг;

Монголчуудын үндэсний баяр наадам, баяр цэнгэлийн гол манлай хэсэг нь морь уралдах буюу дааганы уралдаан байдаг, гэвч энэхүү баярын их хүлээлт нь бардам амтай дарга нарын амлалтаас болж бүтэхгүй болж байгааг "оюун дүгнэлт" хийх замаар үндэслэх боломжтойг;

Зах зээлийн өмнөх нийгмийн үед "нэгдэл" гэдэг ухагдахуун байсныг өнөөгийн нийгмийн нөхцөлд эргэцүүлэн бодож, иргэний нийгмийн шинэ нөхцөлд шилжүүлэн ойлгох чадварыг; Хүний хүмүүжлийн чухал шинжүүр нь "хариуцлага" байдгийг шүлгээс олж, сурагчид өнөөгийн амьдралтай зөв холбож, үндэслэн тайлбарлах чадварыг энэхүү шүлэг ашиглан илрүүлж байсан юм.

6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдлийн хөгжлийн зарим онцлог

Монгол хэлний эх зохиох үйлийн явцад 6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэх чадварын онцлогийг судалгааны явцад тодорхойлох оролдлого хийлээ.

Хүснэгт 1

6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдлийн хөгжлийг харьцуулсан судалгаа (СБн-ээр)

№	Судалгаанд хамрагдсан сурагчдын тоо	Нас	Сэтгэхүйн үйлдлүүд					Ухагдахуун үүсгэх	Ургуулан бодож, сэтгэмж үүсгэх	Оюун дүгнэлт хийх
			Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх	Жиших	Хийсвэрлэх	Ерөнхийлөх	Тодруулах			
1	7000	6	0,0017	0,0016	0,0021	0,0022	0,0015	+	+	+
2	7000	7	0,0044	0,0043	0,0031	0,001	0,0016	+	+	+
3	7000	8	0,0065	0,0064	0,004	0,0033	0,0026	+	+	+
Дүн			0,0126	0,0123	0,0092	0,0065	0,0057	+	+	+


Хүснэгт-1-ээс үзэхэд 6-8 насны сурагчдын задлан шинжилж, нэгтгэн дүгнэх үйлдэл жиших үйлдлээс 0,0003-аар, хийсвэрлэхээс 0,0034-өөр, ерөнхийлөхөөс 0,0061-ээр, тодруулахаас 0,0069-өөр тус тус илүү сэтгэхүйн бүтээмжтэй гарлаа.

Өгүүлбэр нь тодорхой утга санааг илэрхийлж, түүний уялдаа холбоо дараагийн өгүүлбэрээр тодотгогдож, ерөнхийлөн дүгнэгдэж байдаг нь сурагчдын сэтгэхүйн үйлдэл шатлан хөгждөгийг тодорхойлох боломж олгосон юм.

Бүдүүвч 1

6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдлийн хөгжлийг харьцуулсан судалгаа

(Монгол хэлний эх зохиох үйлийн жишээн дээр)




Бүдүүвч-1-ээс үзэхэд, монгол хэлний эх зохиох үйлийн явцад сэтгэхүйн задлан шинжилж нэгтгэн дүгнэх, жиших, хийсвэрлэх, ерөнхийлөх үйлдэл хийх, хэрэглэх чадвар өндөр гарч, харин тодруулах үйлдлийн хөгжил харьцангуй буурай байгаа нь эх зохиох үйлийн дотоод онцлогтой холбоотой байлаа. Иймд сэтгэхүйн хийсвэрлэх, ерөнхийлөх, тодруулах үйлдлүүд монгол хэлний эх зохиох явцад илүү хөгжих боломжтой нь харагдсан юм.

Хүснэгт-2-оос үзэхэд задлан шинжилж нэгтгэн

дүгнэх үйлдлийн ерөнхий бүтээмж 0,0313, жиших үйлдлийн бүтээмж 0,0304, хийсвэрлэх үйлдлийн бүтээмж 0,023, ерөнхийлөх 0,0135, тодруулах 0,0069 тус тус гарав. Ялангуяа, монгол хэлний эх зохиох үйлийн явцад сэтгэхүйн задлан шинжилж нэгтгэн дүгнэх (ЗШНД) үйлдэл илүү хөгжиж байгаа нь төрөлх хэлээрээ ярих, унших, бичих, зохиож бичих явцад энгийнээс нарийссан тулгуур ухагдахуун ямагт өгөгдөж байдгаас шалтгаалдаг нь харагдлаа. Бүдүүвч-2 нь 6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдлийн хөгжлийн онцлогийг үйлдэл тус бүрээр нь авч үзсэн үр дүнг харуулж байна. Судалгааны явцаас үзэхэд монгол хэлний эх зохиоход сэтгэхүйн задлан шинжилж нэгтгэн дүгнэх үйлдэл илүү хэрэглэгдэж, энэ утгаараа бусад үйлдлээс илүү хөгжих боломжтой байдаг нь ажиглагдаж байна. Түүнчлэн сэтгэхүйн хийсвэрлэх, ерөнхийлөх, тодруулах үйлдэл тодорхой шатлалаар ахиж хөгждөг нь харагдлаа. Эх зохиоход үгийн сонголт хийх, дам утгыг уран сэтгэмжээр илэрхийлэх зэрэг чадварууд харьцангуй бэрхшээлтэй тулгарч хөгжиж байлаа.

Бүдүүвч 2

6-8 насны сурагчдын сэтгэхүйн ЗШНД үйлдлийн хөгжлийг сэтгэхүйн бусад үйлдэлтэй харьцуулсан судалгаа (Монгол хэлний эх зохиох үйлийн жишээн дээр)



Хүснэгт 2

6-8 насны сурагчдын сэтгэхүйн ЗШНД үйлдлийг сэтгэхүйн бусад үйлдэлтэй харьцуулсан судалгаа (Монгол хэлний эх зохиох үйлийн жишээн дээр)

№	Сэтгэхүйн үйлдлүүд	СЕБ	ЗШНД	Жиших	Хийсвэрлэх	Ерөнхийлөх	Тодруулах	Зөрүү
1	ЗШНД	0,0313	0,0313					
2	Жиших	0,304		-0,0009				-0,0009
3	Хийсвэрлэх	0,023			-0,0083			-0,0083
4	Ерөнхийлөх	0,0135				-0,0178		-0,0178
5	Тодруулах	0,0069						
Дүн						0,024		-0,0244

Судалгааны үр дүнгээс

Монгол хэлний эх зохиох үйлийн явцад 6-8 насны суралцагчид өөрийн бодол санааг тодорхой эрэмбэ дарааллаар илэрхийлэх, далд утгыг оновчтой тодорхойлж, утга төгс ярьж, бичих чадвар нь нэмэгдэж, эх зохиох ажилд сэтгэхүйн үйлдлээ сонгон хэрэглэх чадвартай болж байв. Ялангуяа, үгийг хувиргах замаар шинэ үг бүтээж, ургуулан бодох замаар шинэ ухагдахуун үүсгэж, хуучин буюу шинэ ухагдахууны холбоо хамаарлыг олж, утга санаа өгүүлэмжийг зөв гаргаж, оюун дүгнэлт хийж, оновчтой ашиглах чадвар төлөвшиж байлаа.

Өгөгдсөн үгийг зургаар илэрхийлэх явцад зургийг (нар, цэцэг) дүр болгон хувиргаж, тодорхой агуулгаар нь нэгтгэн, хоёр нэрээс бүтсэн нийлмэл нэр бүтээж, хүнд хамааруулж утгын холбоо үүсгэн тухайн сурагчийн сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэх чадвар хөгжиж байв. Тухайлбал, зургийн санааг үгийн утгад шилжүүлэн өөрийн үгээр илэрхийлэх боломж бүрдэж буй нь ажиглагдлаа. Судлуулагч-сурагч мишээж буй нар, дэлбээлж буй цэцгийн дүрсийг задлан шинжилж нэгтгэн дүгнэх замаар сэтгэхүйн үйлдэл хийж, ургуулан бодох үндсэн дээр оюун дүгнэлт хийж “Наранцэцэг” гэдэг хүний нийлмэл нэрийг бүтээж буй нь нэг талаас сэтгэхүйн үйлдэл хийх, нөгөө талаас сэтгэхүйн үйлдэл хэрэглэж, оюуны арга барилд суралцах боломжтой байв.

Өгөгдсөн сэдлээр үг, өгүүлбэр бүтээж, унших явцад тухайн сурагчдын сэтгэхүйн үйлдэл хөгжин төлөвшиж, шинэ нөхцөлд оюуны арга барил хийх, хэрэглэх чадварт илүү суралцах боломж байгааг өргөн ашиглах нь чухал юм.

Өгөгдсөн үсгүүдээр үг бүтээлгэж график зохиох явцад 6-8 насны сурагчдын сэтгэхүйн

үйлдэл шатлан хөгжих боломжтой байна.

Утга санааг олж батлах даалгаврыг тодорхой үе шатаар хийлгэж 6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлж болно. Үүнд:

- Салангид үгсийг тогтоож, утгыг үндэслэх,
- Утгын холбоо бүхий хос үгийг агуулгаар нь зөв холбох дадлага ажил хийлгэх,
- Шүлэг тогтоолгож, далд утгыг үндэслэх бүтээлч ажил хийлгэх замаар сэтгэхүйн үйлдлийг шатлан хөгжүүлж, сэтгэхүйн дээд үйлдэлд дэвшүүлэн төлөвшүүлэх боломжийг өргөн ашиглах нь чухал юм.

Өгөгдсөн сэдвээр эх зохиох, өөрөө зохиож бичих явцад 6-12 насны сурагчдын сэтгэхүйн үйлдэл агуулгын шинэ төвшинд хөгжих боломжтой байдаг нь харагдлаа.

Уран зохиолын эх зохиож бичих явцад сурагчдын сэтгэхүйн үйлдэл хийх, хэрэглэх чадвар нэмэгдэж, тэдний уран сэтгэмж, дүрийн төсөөлөл, дүрслэлийн сэтгэхүй эрчимтэй хөгжиж байна.

Иймд 6-8 насны сурагчдаар монгол хэлний эх зохиолгох, тайлбарлан яриулах зэрэг бүтээлч ажлыг тодорхой дэс дараалалтай, тогтмол хийлгэж байвал тэдний сэтгэхүйн үйлдэл хөгжих боломжтой байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Дашхүү. Д. Батдэлгэр. Ж. Мягмар.О. Бага ангийн сурагчдыг судлах аргазүй. Уб., 2000
2. Долгор.Г., Бага сургуульд явуулах бичгийн ажлын хэлбэрүүд. Бага сургуулийн багш нарт тусламж. №2. УХГ.,1969., 50-53 тал
3. Дэжээхүү.Ц. I ангид үзэх жинхэнэ нэрийн тухай. Бага сургуулийн багш нарт тусламж. №2. УХГ.,1969., 8-18 тал4.
4. Дэжээхүү.Ц. I ангийн монгол хэлний номыг ашиглахад тусламж, Бага сургуулийн багш нарт тусламж. №2. УХГ.,1969., 36-44 тал
5. Өлзийханд.Х. II ангийн хэлний зүйн зарим дасгалуудыг ажиллуулахдаа анхаарах зүйлийн талаар зөвлөө. Бага сургуулийн багш нарт тусламж. №2. УХГ.,1969., 44-50 тал
6. Содномваанчиг. Г нар. 11 жилийн сургалтын төлөвлөгөө, агуулгын хүрээний туршилтын тайлан. Уб., 2006
7. Цэвэгжав.Б. Тийн ялгал заах тухай. Бага сургуулийн багш нарт тусламж. №2. УХГ.,1969., 53-58
8. Цэвээнлхазал.Я, Алтанхуяг.Ц. Хүмүүсээ! Би чадна Хөгжлийн бэрхшээлээ засна. Уб., 2003
9. Цэвээнлхазал, Я., Алтанхуяг.Ц. Хүүхдийн анхаарлын бэрхшээлийг судлах нь. Сэтгэлзүйн оношлогоо. Цуврал № 2. Уб., 2003
10. Цэвээнлхазал.Я. Сурагчдын сурах бэрхшээлийг яаж илрүүлэх вэ? Сэтгэлзүйн оношилгоо. Цуврал-3 Уб., 2003
11. Цэвээнлхазал.Я, Алтанхуяг.Ц Бага ангийн сурагчдын анхаарлын бэрхшээлийг судлах нь. Уб., 2003
12. Цэвээнлхазал.Я, Алтанхуяг. Ц. Бага ангийн сурагчдын сурах чадварыг хичээлээр оношлох нь. Уб., 2005
13. Цэвээнлхазал.Я. Бага боловсролын сурган хүмүүжүүлэхзүй. Их дээд сургуулийн багш. оюутанд зориулсан сурах бичиг. Уб.,2010
14. Цэвээнлхазал.Я. Мэдлэг бүтээх үйл явцын сургахзүйн үндэс.Уб., 2010
15. Цэвээнлхазал.Я Хүүхдийн сэтгэхүйн хөгжил. Цуврал-1,2,3. Уб.,2010
16. Цэвээнлхазал.Я. Алтанхуяг.Ц, Цогбадрах.З. Хүүхдийн хөгжлийн сэтгэлзүйн үндэс. Тэргүүн дэвтэр Уб.,2010
17. Цэвээнлхазал.Я, Цогбадрах.З. Хүүхдийн хөгжлийн сэтгэлзүйн үндэс. Дэд дэвтэр. Уб.,2010

Лавай. 2011. №6